



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 25

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Д.Оюун даргалж, хувьцаа эзэмшигч Б.Зориг /768606/, Д.Тунгалаг /99192/, Д.Оюун /1279/, Д.Төмөр-Очир /5/, Г.Гансүх /3/, “Би ди сек ҮЦК” ХК /15,283/, түүнийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Хонгор нарыг оролцуулан, хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунаар хөтлүүлэн “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 10 цаг 35 минутад хийв.

Ашигласан цахим хаяг: ZOOM-meeting 867 4700 3067. Цахимаар оролцсон хувьцаа эзэмшигч байхгүй. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүд бүрэн оролцов.

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд, ХЭ-ийн ээлжит хурлын дэгийг танилцуулаад хурлын материалтайгаа харъяа брокер дилерийн компаниараа дамжуулан авсан байх. Компани дээр биечлэн ирж танилцах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигч байхгүй болохыг тэмдэглэлд тусгуулъя.

Хурлаа эхлүүлэхээс өмнө тооллогын комиссын гишүүдээ танилцуулъя гээд Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэл нягтлан бодогч мэргэжилтэй, “Гермес” ХХК-ийн нягтлан бодогч ажилтай, П.Сумъяасугар тус компанийн Гадаад харилцаа, тээвэр ложистикийн хэлтэст тээврийн менежерээр ажилладаг, манай компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн болон ашиг сонирхлын зөрчилгүй, манай компанийн хувьцаа эзэмшдэггүй, тооллогын комиссын гишүүн П.Сувдаа тус компанийн эрүүл ахуйчаар ажилладаг, тооллогын комиссын гишүүд бүгдээрээ манай компанийн хувьцаа эзэмшдэггүй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Одоо цаг 10 цаг 35 минут болж байна, комиссын дарга, гишүүд ирцийн бүртгэлийг дуусгаж, ирцийн мэдээгээ танилцуулъя.

Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нэгбүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийв. Ирцийн ажиллагаа 10:00 цагаас эхэлсэн болно.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Ирцийн мэдээллийг хуралд танилцуулж, 884,368 ширхэг саналын эрх бүхий хувьцаатай 06 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Ирцийн дүн 64,63% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Тооллогын комисс ирцийн бүртгэлээ хийж, ирцийн мэдээгээ танилцууллаа
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, батлах
- Хөрөнгийн үнэлгээний байгууллагыг сонгох, эрх олгох
- “Материал кредит ББСБ” ХХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэх, эрх олгох, дүрэм шинэчлэн батлах

- Ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлэл, тайлбар сонсох
- Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариулт
- Тооллогын комиссоос, саналын хуудсыг бөглөх зааврыг өгч санал хураалт явагдана.
- Саналын хуудас тоолох явцад хурал түр завсарлана.
- Тооллогын комиссоос саналын хуудасны дүнг танилцуулна.
- ХЭХ-аас гарах тогтоолыг танилцуулж, батлуулна.
- Хурлыг хаана. Ийм дарааллаар өнөөдрийн хурал явагдана.

Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Биржийн сайтад байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан. Өдрийн сонинд 2025.03.17 ба 2025.04.01-ний өдрүүдэд хурлын зар байршуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг нийтэд мэдээлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд компани дээр хурлын материалыг хэвлэж бэлдсэн байсан боловч хэн ч ирж танилцаагүйг түрүүн хэлсэн. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг гэдгийг дахин хэлье. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхтэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын дэгтэй холбоотой саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэгцгээв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дарааллын талаар асуух асуулт байхгүй бол нэг дэх асуудалдаа орёе. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг миний бие хэлэлцүүлнэ. /ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав/.

Даргалагчаас: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор асуух асуулт байвал хэдийд ч тавьж болно шүү. ТУЗ-ийн дүгнэлттэй холбоотой асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг аудитын хорооны дарга Б.Энх-Амар гишүүнээс хэлэлцүүлнэ.

Б.Энх-Амараас: Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцүүлэв /дүгнэлтийг хавсаргав/. Асуух асуулт байгаа эсэхийг тодруулахад

Оролцогчдоос: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Б.Зоригоос хэлэлцүүлэе.

Б.Зоригоос: Энэ жилийн тухайд их товч төлөвлөгөө байгаа. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг үргэлжлүүлэх, өмнөх онуудад эхлүүлсэн барилгын 2 төслөө дуусгах, 2027 онд болох компанийн 70 жилийн ойн арга хэмжээг угтсан бүтээлч ажлуудыг эхлүүлэх гэсэн үндсэн төлөвлөгөөтэй. Хийж гүйцэтгэх ажлын 36 ажлыг багцлан оруулсан гээд уншиж танилцуулав.

Би ди сек ҮЦК ХК /Б.Хонгор/-с: Миний хувьд компаниа төлөөлж итгэмжлэлээр өнөөдрийн хуралд оролцож байна. Бизнес төлөвлөгөөг харахад хийх ажлаасаа илүүтэй тоон мэдээлэл, дүнтэй төлөвлөгөө байх ёстой юм бишүү. Арай л халтуурдаад байх шиг байна гэв.

Даргалагчаас: Хувьцаа эзэмшигчийн саналыг хүлээн авч байна. Манай хэлтэс нэгж туцс бүр өөрийн өөрийн хийх ажлын төлөвлөгөөг үнийн дүнтэйгээ гаргаж өгдөг. Тоон үзүүлэлт байлгүй яах вэ. Энэ удаад онцгойлон хувьцаа эзэмшигчдээр батлуулах хөрөнгө оруулалт, бусад зүйл байхгүй байсан учраас хийх ажлыг илүү чухалчилж бизнес төлөвлөгөөгөө хийхийг зорьсон. Энэ тал дээр анхаарч ирэх жилийн төлөвлөгөөндөө тоон мэдээллийг тусгая. Ер нь нийтэд ил тод тоон мэдээлэл бүхий төлөвлөгөөгөө байршуулсан ч болох юм байна, ойлголоо.

Б.Зоригоос: Бизнес төлөвлөгөөнөөс асуух асуулт байна уу?

Оролцогчид: Одоохондоо асуух асуулгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлынхаа дараалал ёсоор ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв, гишүүн , дарга, нарийн бичгийн даргын цалин урамшууллын тухай ЦУХ-ны дарга Ц.Ариунаагаас хэлэлцүүлнэ.

Ц.Ариунаагаас: ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв, гишүүн , дарга, нарийн бичгийн даргын цалин урамшууллын тухай саналаа танилцуулаад асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асуухад

Оролцогчид: Байхгүй гэв. /ЦУХорооны саналыг хавсаргав/

Даргалагчаас: Асуух асуулт, тодруулах зүйл, санал, хүсэлт алийг нь ч хэлэлцэж буй асуудлын аль ч үед асууж, хэлж ярьж болно шүү. Жил бүр уламжлал болон хийгддэг, дандаа ирдэг хувьцаа эзэмшигчид маань ирсэн болхоор асуух асуултгүй байх шиг байна. Хөндлөнгийн аудитын байгууллагын талаарх Аудитын хорооны саналыг П.Баатарцэрэн гишүүнээс хэлэлцүүлэе.

П.Баатарцэрэнгээс: Өөрийгөө танилцуулаад, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүд аудитын байгууллагуудыг багагүй судалж үзсэн. Үнэт цаасны компаниудад СЗХ-ны тусгай зөвшөөрлөөр аудит хийх эрх олгогддог бөгөөд энэ дагуу СЗХ-нд бүртгэлтэй буюу эрхтэй 54 байгууллага байдаг юм байна. Энэхүү 54 байгууллага бүртэй холбогдоогүй, эхний ээлжид шүүлтүүр хийж, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 4 аудитын байгууллагуудыг шууд хассан. Дараа нь хаяг нь тодорхойгүй 2 байгууллага, Багануур, Багахангай, Налайх, Баянзүрх болон СХД дүүргүүдэд оффистой байгууллагуудыг бас хассан. Шалтгаан нь мэдээж аудитын байгууллага жилийн туршид манай байгууллагатай холбоотой байдаг, замын түгжрэл болон бусад байдлыг харгалзан үзээд үлдсэн байгууллагуудаас үнийн санал эхлээд авсан.

Гэтэл эргээд холбогдоё гэсэн газруудаас зарим нь эргэж холбогдоогүй. Томоохон аудитын байгууллагуудын үнэ хэт өндөр байна. Ер нь аудит хийх үнэлгээ, ажлын хөлс өмнөх жилүүдээс энэ жил өссөн байгаа гэдгийг мэдэж байгаа хэдий ч хэт өндөр үнийн санал ирүүлсэн газрууд багагүй байна. Өндөр үнийн дүн гарах учир нь манай байгууллагын орлого хэдэн арван тэрбум учраас тэрхүү дүнтэй харьцуулагдаж үнийн санал гараад байгаа юм.

Ингээд хорооны гишүүд зөвшилцөөд 2023, 2024 онд манай байгууллагын хөндлөнгийн аудитаар ажилласан “Ниямазон аудит” ХХК-ийг сонгож хийлгэхэд хөндлөнгийн байр суурь алдахгүй, хараат бус байдалд нөлөөлөхгүй гэж үзсэн тул энэ байгууллагатайгаа дахин хамтран ажиллах саналыг ХЭХ-д оруулж байна. Асуух тодруулах зүйлд хариулъя гэв.

Оролцогчид: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Бас нэг зүйлийг тодруулан хэлэхэд Аудитын тухай хууль өөрчлөгдсөнтэй холбоотой аудитын байгууллагуудын үйл ажиллагаа, хяналт арай өөрчлөгдсөн. Мөн аудиторуудын маань чадвар, чадамж хэр байгааг хараахан мэдэх боломжгүй байна. Манай компанийн үйл ажиллагаанд тохирсон, зөвлөмж зөвлөгөө сайн өгдөг, хөндлөнгийн байр сууриа тогтвортой хадгалдаг гэх мэтчилэн шалгуурыг хангасан байгууллагыг цаашид олж тогтоох, судлах ажлыг хийх шаардлагатай юм байна гэж энэ жилийн судалгаанаас дүгнэж байгаа.

Хуралд оролцогчдоос асуух асуултгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе. Хөрөнгийн үнэлгээний байгууллагыг сонгох талаар Ш.Ганзориг гишүүнээс хэлэлцүүлнэ.

Ш.Ганзоригоос: Хөрөнгийн үнэлгээг бол аудитын байгууллага шиг заавал СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авдаггүй юм байна. Зах зээлд маш олон хөрөнгийн үнэлгээ хийдэг байгууллагууд байна. Бид судалгаа хийхдээ Монголын мэргэшсэн Үнэлгээчдийн холбоо-нд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг судалсан. Ер нь бол хөрөнгийн үнэлгээг хуульд зааснаар тодорхой хугацаанд үнэлүүлж явах ёстой, үүнийг заавал ХЭХ-аар хэлэлцүүлэх шаардлагагүй. Энэ нь өөрөө ТУЗ-ийн эрх хэмжээний асуудал мөн. Энэ жил яагаад ХЭХ-аар хэлэлцүүлж байгаа вэ гэхээр Хувьцаа эзэмшигчиддээ үнэлүүлэх хөрөнгүүдийнхээ талаар тайлбар хийх, мэдээлэл өгөх зорилготой. Компани дээр бүртгэлтэй хөрөнгө бүрт хийх боломжгүй юм байна. Социализмын үеийн хөрөнгийг сүүлд үнэлсэн үнэлгээ бүхий хөрөнгө байна. Гэхдээ одоо хөрөнгө нь байгаа хэдий ч ашиглалтгүй хөрөнгө байна. Тухайлбал, хуучин модон агуулах, огт ашиглах боломжгүй болсон байгаа, хуучин цемент, бетон зуурмагийн узель байна. Үнэлгээ

хийгдчихсэн. Боломжийн зах зээлийн үнэлгээтэй хэрнээ үйл ажиллагаа байхгүй. Мөн бартерт орж ирээд гардаг түр хугацааны хөрөнгө гэж байна гэх мэтчилэн зарим нэг хөрөнгүүдээ дахин үнэлүүлэх шаадлагагүй, үлдсэн хөрөнгүүдийнхээ жагсаалтаар үнэлгээ хийлгэнэ гэсэн санал манай хороонд байгаа. Энэ удаад хувьцаа эзэмшигчид маань мэдээлэл авсан бол нэгэнт хэлэлцэх асуудалд орсон учраас хөрөнгийн үнэлгээ хийх байгууллагаа сонгоод, гэрээгээ хийгээд, үнэлгээгээ хийлгэх ажлыг ТУЗ-дөө даалгах гэх юм уу эрх олгох гэх юм уу, ийм байдлаар шийдвэрлүүлэх саналтайгаар өнөөдрийн хуралд хэлэлцүүлж байна гэв.

Даргалагчаас: Хөрөнгийн үнэлгээ хийлгэх байгууллагаа сонгоод хийлгэх эрхийг ТУЗ-д олгоход болохгүй гэх хууль эрх зүйн ямар нэгэн зүйл байхгүй. Сая хэлсэнчлэн тайлбар, мэдээлэл өгөх зорилготойгоор өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудалд оруулсан. Магадгүй хувьцаа эзэмшигчдээс тийм байгууллагаар хийлгэе гэсэн санал гарч болзошгүй учраас хэлэлцэх асуудалдаа заавал оруулсан юм шүү. Хувьцаа эзэмшигчдийн хувьд хэрхэн саналаа өгөх нь нээлттэй, чөлөөтэй. Үүнтэй холбоотой асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудлыг миний бие өөрөө хэлэлцүүлээд манай хуулийн мэргэжилтэн Т.Лхагвачулуунаас тодруулаад явна.

Материалимпэкс ХК-ийн хувьцаа эзэмшигчид ББСБ байгуулъя гэсэн санааг анх 2017 онд гаргаж, 2018 оны ХЭХ-аар дэмжигдэж, “Материал кредит” ХХК-иа анх үүсгэн байгуулсан. Гэсэн хэдий ч 2,5 тэрбум төгрөгийг нэгдөр байршуулахад компанийн хөрөнгө санхүү, цаг хугацаа шаардлагатай болж, улмаар ковидын үе эхэлж, хойшлогдсоор байсан. 2024 онд тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох нөхцөл үүссэнээр 2024 оны 04 дүгээр сард СЗХ-нд хүсэлтээ албан ёсоор гаргасан. Хүсэлтийг зөвхөн нэг албан бичиг гаргаад л болчихгүй, маш их дүрэм, журам боловсруулж, бичиг баримтын өндөр шаардлагыг биелүүлэх хэрэгтэй юм байна лээ. Ингээд 2024.11.25-ны өдөр СЗХ-ны 552-р тогтоолоор ББСБ-ын Зээл-ийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх зөвшөөрлөө авч, бичиг баримтуудаа солих, бүртгүүлэх гээд бас хуульд заасан хугацааны дотор бүрдэл хангах ажлуудаа хийсээр 2024 оныг дуусгасан. 2025 оны 01 дүгээр сараас оффисын байраа тохижуулах, эдийн засагчтай болох гээд дараагийн бэлтгэл ажилдаа орж, 2025 оны 02 дугаар сараас зээлээ гаргаж эхэлсэн. Одоогийн байдлаар 2 зээлийн эдийн засагчтай, нягтлан бодогч болон комплайнсын ажилтан, гүйцэтгэх захирал гэсэн 3 албан тушаалыг Материалимпэксийн 3 албан тушаалтан давхар хариуцан хийж байна. Гаргаад байгаа зээлийн тухайд өнөөдрийн байдлаар 1 тэрбум орчим төгрөгийн зээл гарсан ба эрсдэлтэй зээл аль болох гаргахгүй эрмэлзэж байгаа хэдий ч зээл гарснаас хойш 6 сарын дараа л эрсдэлтэй эсэх нь харагдах бас цаг хугацааны асуудал байгаа. Гэвч бид одоохондоо эрсдэл учрахгүй байх гэсэн итгэл дүүрэн байна.

Т.Лхагвачулуунаас: манайхыг ББСБ-ын тусгай зөвшөөрөл авах үед дүрмийн сан 2,5 тэрбум төгрөг байсан, гэтэл энэ дүнг өсгөхөөр СЗХ-ны 2024 оны 555-р тогтоол гарсан. 2026.04.10-ны дотор 3,5 тэрбум, 2028.04.10 гэхэд 5 тэрбум төгрөгөөр дүрмийн сангаа нэмэгдүүлсэн байхыг эрх бүхий байгууллагаас шаардсан. Гэтэл манай ББСБ-ын тухайд дөнгөж үйл ажиллагаагаа эхэлж байгаа, жилийн дотор нэг тэрбум төгрөгөөр дүрмийн сангаа нэмэгдүүлэх ямар ч эдийн засгийн боломжгүй. Иймд бид арай гэж олж авсан тусгай зөвшөөрлөө ийм байдлаас болж цуцлуулахад хайран, мөн ирээдүйн үнэ цэнэ, ашигтай ажиллах бүрэн нөхцөл боломж, төлөвлөгөө байгаа зэрэг олон сайн нөхцөл байдлуудыг харгалзан дүрмийн сангийн 2026 оны нэмэлтийг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч “Материалимпэкс” ХК-иасаа хүсэж байна. Харин 2028 оны 1,5 тэрбум төгрөгийн өсөлт буюу дүрмийн сангийн нэмэгдлийг ББСБ бид өөрийн үйл ажиллагаагаар нэмэгдүүлнэ гэж итгэж байгаа. Ийм зорилттой ч ажиллах болно. Ммэдээж хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагчдаа жил бүр ногдол ашиг хэлбэрээр хөрөнгө оруулалтыг буцаан төлнө.

Дүрмийн сан хэрэв өөрчлөгдвөл манай ББСБ-ын “Дүрэм”-д өөрчлөлт орж, санхүүгийн тайлангаа гаргаж, хуульд заасан ажилбарууд явагдана. Мөн бид ББСБ-ын үйл ажиллагаагаа шинээр баригдсан “Мета центр” худалдааны төв дотор оффисоо нээсэн тул өмнөх дүрэмд дурдсан хаягийн өөрчлөлтийг бас оруулах шаардлагатай болж байгаа юм.

Одоо бидэнд бас нэг тулгараад байгаа асуудал бол ББСБ-ын данснаас зээл гаргахад гүйцэтгэх захирал нийт хөрөнгө оруулалтын хэмжээгээр зээл гаргах эрхтэй юу, зээл болон хадгалмжийн хүү нэмсэн дүнгээр зээл гаргах эрхтэй юу гэдэг асуудал гарч ирдэг юм байна. Өрөөр хэлбэл 2,5 сая төгрөг маань эргэлтэнд ороод өсөхөд дүрмийн сангаасаа давсан зарцуулалтыг хийх эрх гүйцэтгэх захиралд байгаа эсэх асуудал яригддаг юм байна. Энэ хүрээнд мэдээж зээл гарч байгаа л бол хүү орж ирнэ, тэгэхээр манай 2,5 тэрбум төгрөг эргэлтэд орж, хүүгийн хэмжээгээр өснө. Иймд нэмж хөрөнгө оруулалт хийж, дүрмийн санг өсгөсөн ч бай үгүй ч бай ер нь ББСБ-ын гүйцэтгэх захирал нь дүрмийн сангаараа хязгаарлагдахгүйгээр, компанид орж ирсэн орлого, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг олгох нь зүйтэй юм байна гэсэн саналыг мөн хэлэлцүүлж байна.

Асуух асуулт, тодруулах зүйл байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: ХЭХ-аар хэлэлцэж, батлах асуудлууд ерөнхийдөө үүгээр дуусч байна. Одоо та бүхэнд Ногдол ашгийн талаарх мэдээллийг Аудитын хорооны дарга Б.Энх-Амараас танилцуулна.

Б.Энх-Амараас: ТУЗ-ийн 2025.02.11-ний өдрийн 09 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 150 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсэн гэв.

Даргалагчаас: Асуух асуулт байна уу?

Д.Төмөр-Очироос: Ногдол ашгаа хэдий хугацаанд ямар хэлбэрээр тараах вэ?

Б.Энх-Амараас: 2025.04.30-ны дотроо багтаан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараахаар гэрээгээ хийгээд байгаа гэв.

Оролцогчид: Өөр асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлууд дууслаа, асуулт хариултын дараалалдаа орёе. Одоо нийгээр нь сонсоод асуух зүйл гарсан байж магадгүй. Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт, санал, хүсэлт аль нь ч байж болно.

Г.Гансүхээс: Өнөөдрийн хэлэлцсэн асуудлуудтай хамааралгүй зүйл асууя. Евразийнэдийн засгийн 5 орны түр гэрээ байгуулах талаар их яригдаж байна. Хүнсний төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс их дургүй хандлагатай байсан. Манай байгууллага холбоо тогтоовол ер нь боломж байгаа юу? Энэ талаар бодож төлөвлөсөн зүйл бий юу?

П.Баатарцэрэнгээс: Зам энэ асуултад хариулья. Манай байгууллагаас евразийн эдийн засгийн холбооны талаар багагүй хэмжээнд судалж байгаа. Манай байгууллага бол МҮХАҮТанхимын гишүүн байгууллага. Бид МҮХАТанхимаар дамжуулан өөрсдийн саналаа илэрхийлсэн. Товчдоо бол дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Манай хувьд элсэн чихэр, цагаан будааны импортыг хийдэг. Энэ холбоонд нэгдсэнээр гаалийн татвар буурах эерэг тал байгаа ч премиум сахар буюу Вьетнам, Тайланд сахарын үнэ өсөх буюу доголдож болзошгүй харагдаж байгаа. Одоогийн байдлаар засгийн газраас барааны нэр төрлийн жагсаалт гэж гараагүй байгаа, ер нь бол манай үйл ажиллагаанд эергээр ч, сөргөөр ч нөлөөлж болно гэв.

Г.Гансүхээс: Тээвэр зуучийн байгууллагуудыг хотоос гаргана гээд л байдаг. Одоо энэ Богд уулыг нүхэлж төмөр зам тавина л гээд байна. үүнтэй холбоотой эртхэн нэг газар олж авах талаар бодож байгаа юу?

Б.Зоригоос: Тээвэр зуучийн байгууллагуудыг хотоос гаргах асуудал бол ер нь 20-иод жилийн өмнөөс яригдаж байгаа. 2012 оноос нэг хэсэг эрчимтэй яригдсанаар Улаанбаатар хотын ложистикийн нэгдсэн төв нэртэй 18 байгууллагууд хамтран хувь эзэмшиж, Туушин компани ахалж, Нийслэл буюу хот 18-20%-ийг эзэмшихээр болж байсан. Гэсэн ч энэ хэсэг 2, 3 жил яригдаж байгаад л таг чиг болон унтарсан. Сүүлд Нямбаатар хотын дарга болсны дараа энэ асуудлыг хэсэг бас ярьсан, гэсэн ч тэгээд л таг чиг чимээгүй л байна. Энэ асуудлууд үе үе гарч ирээд байдаг учраас бид энэ талбайдаа дорвитой хөрөнгө оруулалтыг хийж чаддаггүй өнөөдрийг хүрсэн. Төмөр зам барих, солих ажил бол багагүй хөрөнгө шүү дээ. Бид бол нэгдсэн төв байгуулахыг аль ч талаар нь дэмжсээр ирсэн, одоо ч дэмжиж байгаа. Гэсэн хэдий ч энэ асуудал бол биднээс, манай байгууллагаас шалтгаалахгүй нөхцөл байдлын хүрээнд өнөөдөр ч үйл ажиллагаагаа эндээ явуулсаар байна. Ер нь бол Улаанбаатар хот дотроо АБТЭМА, манайх 2 төмөр замын маш их ажлыг бас хуваалцаж байгаа. Манай энэ салбар, салаа төмөр замууд



байхгүй бол өртөөн дээр вагон овоорох асуудал гарна. Өмнөх жилд Тянжинь боомтоос бөөн бөөнөөр чингэлэг ирж байхад манай 2 л ихэнх ачаалал, даацыг өөрийн талбайгаараа үүрч гаргасан. Тийм ч учраас цагий нь тулгаад шууд одоо яв гар гэхгүй байх гэж найдаж байгаа гэв.

Г.Гансүхээс: Сая шинээр баригдсан орон сууц ямар үнээр борлуулагдаж байгаа вэ? Борлуулалт хэр байна?

Даргалагчаас: Борлуулалт 70 гаруй хувьтай борлуулагдсан, 3 өрөө болон 50 мкв талбайтай 2 өрөөнүүд бүгд дууссан. Жижиг 40-42 мкв бүхий 2 өрөө байрнууд л цөөн үлдсэн байгаа. Нэг мкв нь 4,500,000 төгрөгөөр борлуулагдаж байгаа. Энэ бол манай хөрөнгө оруулагч талын мөнгө учраас манай байгууллагаас банкны зээлээс бусад төрлийн зээлийн нөхцөлөөр худалдан борлуулахгүй байгаа.

Даргалагчаас: Асуух асуулт, санал хураалт дууссан бол санал хураалтдаа орё. Тооллогын комиссоос саналыг хуудсыг тараая.

Тооллогын комиссын гишүүдээс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тарааж, бөглөх зааврыг танилцуулав.

Санал хураалт 12:05 цагт эхлэв.

Хурал 12:05 цагт завсарлаж, хурал 12:10 цагт үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Тооллогын дүнгийн тухай комиссын 01 тоот тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Саналын хуудаснуудаас 884,368 саналын эрх бүхий 6 саналын хуудсыг хүчинтэйд тооцсугай.
2. Хүчингүйд тооцсон саналын хуудас байхгүй болохыг дурдсугай.
3. Хүчинтэйд тооцсон саналын хуудсаар өгсөн санал хураалтыг тоолоход хэлэлцүүлж буй асуудлыг доорх хувиар зөвшөөрснийг тогтоосугай. Үүнд :

- 3.1 Компанийн 2024 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн баталсан – 98,3%, татгалзсан – 1,7%;
- 3.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн – 98,3%, түдгэлзсэн – 1,7%;
- 3.3 Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн – 98,3%, татгалзсан – 1,7%;
- 3.4 ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээг батлахыг зөвшөөрсөн – 98,3% татгалзсан – 1,7%;
- 3.5 Хөндлөнгийн аудитын байгууллагаар “Ниямазон аудит” ХХК-ийг сонгохыг зөвшөөрсөн – 98,3%, түдгэлзсэн – 1,7%;
- 3.6 Хөрөнгийн үнэлгээ хийх байгууллагыг сонгох, гэрээ хийх, эрхийг ТУЗ-д олгохыг зөвшөөрсөн – 98,3%, түдгэлзсэн – 1,7%;
- 3.7 “Материал кредит ББСБ” ХХК-дийн дүрмийн санг нэмэгдүүлэх, эрх олгох, дүрэм шинэчлэн батлахыг зөвшөөрсөн – 98,3%, түдгэлзсэн – 1,7%.

Даргалагчаас: Тооллогын комиссын дүн, тогтоолтой холбоотой асуух асуулт байна уу? Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах тогтоолууд гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталж,

2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,

3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02. Утга:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны нийт төсвийг **162,200,000** /Нэг зуун жаран хоёр сая хоёр зуун мянган/ төгрөгөөр баталж,
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн цалин хөлсийг дараах байдлаар тогтоов:
 - 2.1.Ердийн болон хараат гишүүн 900,000*9 /сар бүр, гишүүн тус бүр/ төгрөг;
 - 2.2.Нарийн бичгийн дарга 1,500,000 /сар бүр/ төгрөг;
 - 2.3.Ажил албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга/ - 3,000,000 /сар бүр/ төгрөг;
 - 2.4.Албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /комплайнсын ажилтан/ - 500,000 /сар бүр/ төгрөг.
3. Ажлын онцлогийг харгалзан Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын урамшуулал, нэмэгдэл цалин хөлсийг сар бүр /сар бүрийн 5 ба 20-ны өдрүүдэд/, бусад гишүүдийн урамшууллыг улиралд нэг удаа олгож,
4. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин хөлс, урамшуулал, нэмэгдэл цалин хөлснөөс хуульд заасан шимтгэл, татварыг тухай бүр суутган олгохоор тогтов.

Тогтоол №03. Утга:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол Улсын “Ниямазон аудит” ХХК-ийг сонгож,
2. “Ниямазон аудит” ХХК-тай гэрээ байгуулах, ажлын хөлсний хэмжээг тохиролцох эрхийг тус компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд олгоод,
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд үүрэг болгов.

Тогтоол №04. Утга:

1. Компанийн хөрөнгөд үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагыг сонгож, үнийг тохиролцох, гэрээ хэлцэл хийх зэрэг эрхийг компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд олгон,
2. Компанийн хөрөнгөд үнэлгээ хийсэн талаарх тайланг дараагийн Хувьцаа Эзэмшигчдийн хуралд мэдээлэхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд даалгав.

Тогтоол №05. Утга:



1. “Материал кредит ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ буюу дүрмийн санг 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлж,
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/-г нэмэгдүүлэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 555 дугаар тогтоолд заасан үе шатлалын огноо, хэмжээтэй ижил дүнгээр тухайн жил тутам нэмэгдүүлж болохыг дурдаад,
3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/, хаяг өөрчлөгдсөнтэй холбоотой “Материал кредит ББСБ” ХХК-ийг “Дүрэм”-ийг Хавсралтаар шинэчлэн батлав.
4. Дүрэмд орох өөрчлөлт:
 - 4.1. Компанийн оршин байгаа газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25-р хороо, Үйлдвэрийн төвийн бүс 16010, “Материалимпэкс” ХК-ийн “Мета центр” худалдааны төв, 2-р давхар 26 тоот. Харилцах утасны дугаар: 368384
 - 4.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,500,000,000 /Гурван тэрбум таван зуун сая/ төгрөгийн мөнгөн хөрөнгө байна. Энэхүү хөрөнгө нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,500,000 ширхэг энгийн хувьцаанд хуваагдана.
 - 4.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах байдлаар хувьцааг эзэмшинэ:

№	Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		
			Нэг бүрийн	Бүгд	
1.	"Материалимпэкс" ХК	3,500,000	1,000	3,500,000,000	100%

- 4.4. Компани нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,500,000 ширхэг энгийн хувьцаа гаргах эрхтэй бөгөөд нэрлэсэн үнээс доогуур үнээр хувьцаа гаргахыг хориглоно.
5. Энэ тогтоол гарсантай холбоотой “Материал кредит ББСБ” ХХК-ийн үүсгэн байгуулагчийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот шийдвэрээр баталсан дүрмийг хүчингүйд тооцож,
6. Компанийн шинэчлэгдсэн дүрмийг эрх бүхий байгууллагад хуульд заасан хугацааны дотор бүртгүүлэхийг Т.Лхагвачулуунд үүрэг болгоод,
7. “Материал кредит ББСБ” ХХК-ийн нийт хөрөнгийн хэмжээгээр зээл олгох, захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захирал /Д.Оюун/-д олгов.

Даргалагчаас: Хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 35 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТҮЗ-ийн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУН

